**ХУУЛЬ ЗҮЙН**
**ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТАНИЛЦСАН:
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Төсвийн ерөнхийлөн захирагч

/........................................../ Б.ЭНХБАЯР

ТАЙЛАГНАСАН:
ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ

/........................................../ Х.ЭРДЭМ-УНДРАХ

2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛГО. ХУУЛЬ ЗҮЙН СУДАЛГАА, СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙН БААЗ СУУРИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГОД ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖЛААР ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ ТӨР,ХУВИЙН ХЭВШИЛ, ИРГЭДИЙГ ОНОВЧТОЙ СУРГАЛТ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАНА. | | | | | | | | |
| **ЗОРИЛТ 1. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрх зүйн статус, үндсэн чиг үүргийг хуульчлан баталгаажуулж, түүнд нийцүүлэн боловсон хүчний цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх, гадаад харилцаагаа хөгжүүлэх, сургалт /ХЗҮХ-гийн "2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"/** | | | | | | | | |
| 1.1 | Залуу судлаачдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Улсын төсөв, бусад эх үүсвэр | Сургалтын тоо | 1 | 6 | /I-IV улирал/ | 1. Хууль зүйн ухааны доктор, дэд профессор А.Алтанзул<br>1)Судалгааны арга зүй, аргачлал,<br>2)Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал,<br>3)Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалаар сургалт,<br>2. Хууль, өмгөөлөгч Г.Цагаанбаяр<br>1) Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал,<br>2) Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалаар сургалт,<br>3. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбарын эрхлэгч доктор Н.Мөнхцэцэг "Хууль зүйн нэр томьёог орчуулах, оноох нь" сэдэвт сургалт тус тус орсон. | 100 |
| 1.2 | Гадаад, дотоодын ижил төрлийн чиг үүрэг бүхий байгууллагуудтай харилцан, хамтын ажиллагааг өргөжүүлэх | Улсын төсөв | Хамтран ажилласан байгууллагын тоо | 8 | 9 | /I-IV улирал/ | ХЗҮХ-ийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2023 онд хэрэгжүүлсэн тайлан, 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж ХЗДХЯ-нд хүргүүлэв.<br>1. Япон Улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэн<br>2. Солонгосын хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн (KLRI)<br>3. Солонгосын Хуулийн академи (K-Law academy)<br>4. Итали улсын Ром хотод байрлах UNIDROIT буюу хувийн эрх зүйг ижилтгэх олон улсын хүрээлэн<br>5. ХБНГУ-ын Ханнс-Зайдел сан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 6. БНХАУ-ын Шанхай хотод байрлах Зүүн Хятадын улс төр, хуулийн их сургууль<br>7. Өвөр Монголын их сургуулийн Хууль зүйн сургуулиудтай хамтран ажиллаж байна. | |
| 1.3 | Хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Улсын төсөв | Хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнасан байна. | Тогтоосон хугацаанд гарган ХЗДХЯ-нд хүргүүлсэн. | Тогтоосон хугацаанд ХЗДХЯ-нд хүргүүлсэн байна. | /I-IV улирал/ | Улсын Их Хурлын 2023.07.07-ны өдрийн "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" 77 дугаар тогтоол, Засгийн газрын 2024.01.03-ны өдрийн 01 дүгээр тогтоолын дагуу ХЗҮХ-ээс УИХ-ын Тамгын газарт үл хөдлөх эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг зохион байгуулж 2024.02.28-ны өдөр акт үйлдэн хүлээлцсэн.<br>ХЗДХЯ-ны 2024.03.29-ний өдрийн 4/1470 дугаартай албан бичгийн дагуу ХЗҮХ-ээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтын биелэлтийг гаргаж 2024.04.02-ны өдөр Төрийн захиргаа удирдлагын газрын шинжээч Т.Зулд /zul@mojha.gov.mn/ цахим хаягаар хүргүүлэв.<br>ХЗДХСайдын шуурхайн биелэлтийг гаргаж заасан хугацаанд хүргүүлэв.<br>Хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийн тайланг тухай хүр хүргүүлсэн. | 100 |
| 1.4 | Албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, сургалтыг зохион байгуулах | Улсын төсөв | Сургалтын тоо | 25 удаагийн сургалт зохион байгуулагдсан болно. | 14-өөс доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна. | /I-IV улирал/ | 2024 оны дотоод сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Дотоод сургалтын төлөвлөгөөний эхний хагас жилийн хугацаанд 8 удаагийн арга хэмжээний хүрээнд 24 удаагийн сургалтад хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж, 279 албан хаагч (давхардсан тоогоор) хамрагдсан байна. | 100 |
| 1.5. | Байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ХЗДХЯ-нд хүргүүлэх | Улсын төсөв | Байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг хүргүүлсэн тоо | 2 | 2 | /II-IV улирал/ | Байгууллагын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг 2024 оны 6 сарын 07-ны өдөр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. | 100 |
| 1.6. | Санхүүгийн мэдээллийг байгууллагын цахим хуудас, www.shilendans.gov.mn | Улсын төсөв | Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | Мэдээлэл байршуулах хугацааны | Удирдлагад тогтмол танилцуулж, шилэн | /I-IV улирал/ | Тус хүрээлэнгийн 2024 оны эхний хагас жилийн байдлаар санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд сар бүр, тухай бүр, улирал бүр нийт 56 мэдээллийг оруулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цахим хуудсанд тогтмол хугацаанд байршуулж, олон нийтэд мэдээлэх | | | хоцролт багасаж мэдээллийн агуулга, чанарыг сайжруулж ажиллана. | дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | | Оруулах Оруулсан<br>Тухай бүр 36 36<br>Сар бүр 16 16<br>Улирал бүр 1 1<br>Хагас жилээр 3 3<br>Хугацаа хоцроосон болон мэдээлээгүй мэдээлэл байхгүй. Үүрэг даалгаварын хэрэгжилтийн хувь 100 | |
| 1.7. | Архив, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрээр хөтлөн, албан бичгийн эргэлтэд тавих хяналтыг сайжруулах | Улсын төсөв | "E-doc" цахим системээр хөтөлсөн тоо | Шийдвэрлэлтийн мэдээ тайланг нэгтгэн гаргасан байна. | Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг нэгтгэн гаргасан байна. | /I-IV улирал/ | Эхний хагас жилийн байдлаар 2024.01.01-ний өдрөөс 2024.06.06-ны хооронд:<br>ирсэн бичиг-182,<br>явсан бичиг-243,<br>хугацаандаа шийдвэрлэгдсэн – 170<br>Хянагдаж байгаа – 12<br>Хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн-0 | 100 |
| 1.8. | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх | Улсын төсөв | Өргөдөл гомдлыг шийдвэрлүүлж, тайлан мэдээ гарсан байна. | Тайлан мэдээ гарсан байна. | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлүүлж, тайлан мэдээг гарган удирдлагад танилцуулсан байна. | /I-IV улирал/ | Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдлийн тоо 3, хугацаанд нь хариу өгч шийдвэрлэсэн 3. | 100 |
| 1.9. | Үйл ажиллагааны статистик мэдээ, инфографик мэдээг гарган гарган ХЗДХЯ-ны холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Улсын төсөв | Хүргүүлсэн мэдээллийн тоо | 12 | 12 | /I-IV улирал/ | ХЗҮХ-ийн 2024 оны 1-6 дугаар сарын статистикийн мэдээг ariunjargal@mojha.gov.mn цахим хаягаар болон албан бичгээр заасан хугацаанд ХЗДХЯ-нд хүргүүлж ажилласан. | 100 |
| 1.10. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах | Улсын төсөв | Төлөвлөгөөт ажлын хэрэгжилт | 4 | Бараа ажил үйлчилгээний худалдан авах төлөвлөгөө, холбогдох | /I-IV улирал/ | ХЗҮХ/2024160306 тоот "Монгол Улсын хууль тогтоомжийг англи хэл рүү хөрвүүлэн, мэдээллийн сан бүрдүүлэх" үйлчилгээний тендерийг амжилттай зохион байгуулж 2024.05.02-ны өдөр "Өмгөөллийн Монгол Өмгөөлөгч" ХХН-тэй гэрээ байгуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хууль журмын дагуу зохион өхийгуулсан байна. | | ХЗҮХ/2024160307 тоот "Дохионы хэлмэрч орчуулагчаар хууль зүйн мэдээлэл хүргэх" тендерийг амжилттай зохион байгуулж 2024.05.17-нд "Дохионы хэлмэрч орчуулагчдын холбоо" НҮТББ-тай гэрээ байгуулсан.<br>ХЗҮХ/2024160308 тоот "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл, Хууль дээдлэх ёс сэтгүүл, Судалгааны тайлангийн эмхтгэл хэвлүүлэх" гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг амжилттай зохион байгуулж "Тоонот принт" ХХК-тай 2024.05.06-ны өдөр гэрээг байгуулсан. | |
| **ЗОРИЛТ 2. Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны нэгдсэн сан бий болгох /ХЗҮХ-гийн "2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"/** | | | | | | | | |
| 2.1. | Гадаад, дотоодын судлаачдын эрдэм, шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан зэрэг эх сурвалж, бүтээлийг цахим хэлбэрт оруулж, хайлтын систем бүхий нэгдсэн сан үүсгэх | Улсын төсөв | - Нэгдсэн сан үүсгэж хөгжүүлсэн байх<br>- Санд төвлөрүүлсэн материал, мэдээллийн тоо хэмжээ | 0 | Үүсгэж хөгжүүлсэн байна. | /I-IV улирал/ | Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны сангийн цахим хуудас хийх ажлын даалгавар боловсруулж ажлын даалгаварын дагуу мэдээллийн сангийн дэд бүтцийг хөгжүүлж байна. Мэдээллийн санд оруулах гадаад дотоодын нийт 162 дугаар бүхий эрдэм шинжилгээний өгүүлэл, 570 судалгааны тайлан, 348 судалгааны бүтээл буюу номыг цуглуулсан. | 70 |
| **ЗОРИЛТ 3. Хууль зүйн судалгаа шинжилгээний ажлын чанар, үр нөлөөг сайжруулах./ХЗҮХ-гийн "2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө", Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.7.1-д заасны дагуу эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн нийтлэг харилцаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх** | | | | | | | | |
| 3.1. | Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу судалгаа хийх | 1 | Тогтоосон хугацаанд хийж, ХЗДХЯ-д хүргүүлсэн байна. | /I-IV улирал/ | Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны удирдамж төлөвлөгөө боловсруулсан. Судалгаанд холбогдох эх сурвалжийг түүвэрлэн судалж байна. Тус судалгааг 2024 оны 2-р хагас жилд хийхээр тусгасан. | - |
| 3.2. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу судалгаа хийх | 1 | Тогтоосон хугацаанд хийж, ХЗДХЯ-д хүргүүлсэн байна. | /I-IV улирал/ | "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ". "Цахим хавтаст хэрэг, цахим нотлох баримт, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт" судалгааны тайланг 2024.05.09-ний 01/184 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. | 100 |
| 3.3. | "Иргэний хуулийн хэрэглээнд тулгамдаж байгаа асуудал" сэдэвт судалгаа хийх | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу судалгаа хийх | 1 | Тогтоосон хугацаанд хийж, ХЗДХЯ-д хүргүүлсэн байна. | /I-IV улирал/ | Иргэний хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааг гүйцэтгэж 2024 оны 06 дугаар сарын 30-ны дотор ХЗДХЯ-руу хүргүүлнэ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4. | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу судалгаа хийх | 1 | Тогтоосон хугацаанд хийж, ХЗДХЯ-д хүргүүлсэн байна. | /I-IV улирал/ | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн $14^1$ дүгээр бүлэг буюу "Арбитрын ажиллагаанд шүүх оролцох эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх" судалгааны удирдамж, төлөвлөгөөг боловсруулж, эх сурвалжийн жагсаалт гаргасан. /ХЗССТ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус судалгааг 2024 оны 2 дугаар хагас жилд хийхээр тусгасан/ | - |
| 3.5. | "Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээнд тулгамдаж байгаа асуудал' сэдэвт судалгаа хийх | Улсын төсөв | ЗГ-ын 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу судалгаа хийх | 1 | Тогтоосон хугацаанд хийж, ХЗДХЯ-д хүргүүлсэн байна. | /I-IV улирал/ | Захиргааны ерөнхий хуулийн 27, 28 дугаар зүйлийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж судалгаа гүйцэтгэсэн. Тайланг 2024 оны 6 дугаар сарын 30-ны дотор ХЗДХЯ-нд албан бичгээр хүргүүлнэ. | 100 |
| 3.6. | Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх | | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу судалгаа хийх | 1 | Тогтоосон хугацаанд хийж, ХЗДХЯ-д хүргүүлсэн байна. | I-IV улирал | Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны хүрээг "Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар нэхэмжлэл гаргах, хэд хэдэн оролцогч хамтран нэхэмжлэл гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлэх нь" болгож өөрчилсөн. Тус судалгаанд холбогдох эх сурвалжийг түүвэрлэн судалж, удирдамж төлөвлөгөө боловсруулсан. ХЗССТ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус судалгааг 2024 оны 2 дугаар хагас жилд хийхээр тусгасан. | - |
| 3.7. | Зөрчлийн тухай хуулийн хэрэглээнд тулгамдаж байгаа асуудал' сэдэвт судалгаа хийх | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу судалгаа хийх | 1 | Тогтоосон хугацаанд хийж, ХЗДХЯ-д хүргүүлсэн байна. | I-IV улирал | Судалгааны сэдэв, хамрах хүрээг тодорхойлж, удирдамж, төлөвлөгөө боловсруулсан. /ХЗССТ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус судалгааг 2024 оны 2 дугаар хагас жилд хийхээр тусгасан./ | - |
| 3.8. | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу судалгаа хийх | 1 | Тогтоосон хугацаанд хийж, ХЗДХЯ-д хүргүүлсэн байна. | I-IV улирал | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ сэдвээр судалгааны гүйцэтгэл 90 хувьтай, 2024 оны 7 дугаар сард ХЗДХЯ-нд хүргүүлэхээр төлөвлөж байна. | 100 |
| 3.9. | Хууль зүй, дотоод хэргийн яамнаас | Улсын төсөв | Цаг үеийн шинжтэй судалгаа, | 36 | Тогтоосон хугацаанд | I-IV улирал | ХЗДХЯ-ны захиалгаар нийт 17 судалгаа, 6 лавлагааг хийж гүйцэтгэн тайланг хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ирүүлсэн цаг үеийн шинжтэй судалгаа, лавлагаа хийх | | лавлагааны гүйцэтгэлийн тоо | | хийж, ХЗДХЯ-д хүргүүлсэн байна. | | | |
| 3.10 | Бусад байгууллагаас ирүүлсэн захиалгат судалгаа, лавлагаа хийх | Бусад эх үүсвэр | Захиалагчийн захиалгаар гүйцэтгэсэн судалгаа, лавлагааны ажлын гүйцэтгэлийн тоо | 16 | Ирүүлсэн захиалгын дагуу хийж гүйцэтгэнэ. | I-IV улирал | Монгол Улсын Шүүхийн сахилгын хорооноос ирүүлсэн захиалгын дагуу 2024.05.14-нөөс эхлэн “Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 15, 16-р бүлгийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдэвт судалгааг хийж гүйцэтгэж байна. | 100 |
| 3.11 | “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийг эрхлэн гаргах | Улсын төсөв | Улирал тутамд монгол хэл дээр 1 дугаар | 4 | 4 | /I-IV улирал/ | 2023 оны тусгай дугаар, 2024 оны I болон II улирлын дугаарыг тус тус хэвлэж түгээсэн.<br>МУИС Төв номын сангаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Хууль дээдлэх ёс сэтгүүлийн бүх дугаарыг цахимаар шилжүүлж, хүртээмжтэй байдлыг хангасан.<br>“Хууль дээдлэх ёс /Mongolian Law Journal” барааны тэмдгийг бүртгүүлж, гэрчилгээг авсан | 100 |
| | | | IV улиралд англи хэл дээр 1 дугаар | 1 | 1 | | | |
| 3.12 | Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 онд хийж гүйцэтгэсэн судалгааны тайланг эмхтгэж хэвлүүлэх, нийтийн хүртээл болгох | Улсын төсөв | Судалгааны тайлангийн эмхтгэлийг хэвлүүлсэн эсэх | 3 | 3-аас доошгүй | /I-IV улирал/ | XVI боть /Хувийн эрх зүйн холбогдох судалгаа/, XVII боть /Эрүүгийн эрх зүй болон Зөрчлийн эрх зүйд холбогдох судалгаа/, XVIII боть/ Нийтийн эрх зүйд холбогдох судалгаа/, XIX боть /Үндсэн хуулийн эрх зүйд холбогдох судалгаа/-ийг тус тус эмхэтгэж хэвлэлтэд шилжүүсэн. III улиралд хэвлэлтээс авч нийтэд түгээнэ. | 100 |
| 3.13 | Эрдэм шинжилгээний ажилтнуудыг сургалт, семинарт хамруулах ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Сургалт семинар хэлэлцүүлгийн тоо Хамрагдсан судлаачдын тоо | 25 | Сургалт, семинар, хэлэлцүүлэгт 25-аас доошгүй тооны судлаач хамруулсан байна. | /I-IV улирал/ | Нийт 7 сургалтад давхардсан тоогоох 57 эрдэм шинжилгээний ажилтан хамруулсан. | 100 |
| 3.14 | Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, | Улсын төсөв | Зохион байгуулсан, оролцсон олон | 18 | | /I-IV улирал/ | Тайлант хугацаанд дотоодын 11, олон улсын 3 эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэгийг зохион байгуулж ажилласан байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлэлцүүлэг, уулзалт, семинар зохион байгуулах, оролцох | | улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийн тоо | | 18-аас доошгүй холбогдох сургалт, семинарт оролцсон байна. | | | |
| 3.15 | Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан зохион байгуулах | Улсын төсөв, Чимид сан, | I улиралд Илтгэлийн уралдаан зохион байгуулсан эсэх IV улиралд 2025 оны илтгэлийн уралдааны зарыг түгээсэн эсэх | 1 | 1 | /I-IV улирал/ | Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг 2024.01.11-ний өдөр зохион байгуулсан.<br>Б.Чимидийн нэрэмжит шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтан, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаач, оюутны эрдэм шинжилгээний шилдэг илтгэлийн уралдааныг 2024.01.11-ний өдөр ХЗҮХ-ийн Хуульчдын танхимд зохион байгуулсан. Уралдааны шилдэг илтгэлийг эмхтгэж "Үндсэн хууль ба эрх зүйт ёс"- XV ботийг хэвлүүлсэн.<br>https://nli.gov.mn | 100 |
| 3.16 | Үндсэн хуулийн цэцийн анхны дарга, гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совдын нэрэмжит хууль зүйн сэдэвт шилдэг өгүүлэл шалгаруулах уралдааныг зохион байгуулах | Улсын төсөв | Шилдэг өгүүлэл шалгаруулах уралдааныг зохион байгуулсан эсэх | 1 | 1 | /I-IV улирал | Үндсэн хуулийн цэцийн анхны дарга, гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совдын нэрэмжит хууль зүйн сэдэвт шилдэг өгүүлэл шалгаруулах уралдааныг амжилттай зохион байгуулав.<br>2024.02.13-ны өдөр Галдангийн Совдын нэрэмжит хууль зүйн сэдэвт шилдэг өгүүллийн уралдааны шагнал гардуулав. https //nli.gov.mn/ | 100 |
| 3.17. | 'Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит эрдэм шинжилгээний шилдэг бүтээл, илтгэл шалгаруулах грант олгох төсөл шалгаруулах уралдаан 2024' зохион байгуулахад оролцох, эрдэм шинжилгээний шилдэг бүтээл | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит "Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл, илтгэл шалгаруулах грант олгох төсөл шалгаруулах уралдаан 2024" зохион | 1 | 1 | III дугаар улирал | 2024.04.01-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит "Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл, илтгэл шалгаруулах, грант олгох төсөл шалгаруулах уралдаан 2024" зохион байгуулах тухай" ДХИС, ХЗҮХ-ийн захирлын хамтарсан тушаал батлагдсан. Тус уралдааныг зохион байгуулах бэлтгэл шатны ажлууд үргэлжилж байна. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах | | байгуулахад оролцох, | | | | | |
| 3.18. | Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны тогтмол байдлыг хангах | Улсын төсөв | ЭЗХ-ыг тогтмол хугацаанд зохион байгуулсан эсэх | 1 | 1 | /I-IV улирал/ | Эрдмийн зөвлөлийн хурлыг 2024 оны хоёрдугаар хагас жилд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | - |
| 3.19. | Хууль зүйн хэлний зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааны тогтмол байдлыг хангах | Улсын төсөв | -ХЗХЗ-ийн дүрэм боловсруулж батлуулсан эсэх<br><br>-ХЗХЗ-ийн хуралдаан зохион байгуулсан эсэх | 1 | 1 | /I-IV улирал/ | ХЗХЗ-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмын төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024.03.15-ны А/75 дугаар тушаалаар батлуулсан.<br>ХЗХЗ-ийн гишүүнээр ажиллах байгууллагын төлөөллийн нэрсийг авч ХЗХЗ-ийн анхдугаар хуралдааныг III улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>2024.04.08-ны өдөр Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн тэргүүн Н.Нарангэрэлтэй уулзалт хийж, мэдээлэл солилцсон. | 100 |
| 3.20. | Монгол улсын хууль тогтоомжийг англи хэл дээр орчуулж мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Хууль тогтоомжийг англи хэл дээр орчуулах ажлыг зохион байгуулсан эсэх<br>Хууль тогтоомжийг англи хэл дээрх орчуулгыг мэдээллийн санд байршуулсан эсэх | 157 | Зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу зохион байгуулах | /I-IV улирал/ | ХЗҮХ-ийн захиралын 2023.06.22-ны А/25 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулж тендерийг амжилттай зохион байгуулсан.<br><br>Тус тендэрт “Монгол Өмгөөлөгч” ХХН шалгарсныг үндэслэн 2024.05.02-ны өдөр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. | 100 |
| 3.21. | Гадаад хэлнээс хууль тогтоомж, хууль зүйн бүтээл, эх сурвалжийг монгол хэл дээр орчуулж нийтийн хүртээл болгох | Улсын төсөв | - Хууль тогтоомж, хууль зүйн бүтээл, эх сурвалжийг монгол хэл дээр орчуулсан эсэх<br>- Орчуулгыг нийтийн хүртээл болгосон эсэх | 0 | 1 | /I-IV улирал/ | МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор Б.Буянхишигтэй 24/06 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, ХБНГУ-ын Эрүүгийн процессын хуулийг орчуулах ажлыг гүйцэтгүүлж байна. | 100 |
| 3.22. | Захиргааны хэм хэмжээний актад нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болсонд тооцсон шийдвэрийн дагуу эрх | | - нэмэлт, өөрчлөлт оруулсан актын тоо;<br>хүчингүй болгосон актын тоо | 231 эрх зүйн актад нэмэлт өөрчлөлт, хүчингүй болгосон | Тухай бүрт нэмэлт, өөрчлөлт оруулж, хүчингүй | /I-IV улирал/ | Өөрчлөлт хөдөлгөөн оруулсан 69 актыг хүлээн авсан. Үүнд:<br>нэмэлт, өөрчлөлт оруулсан 44;<br>хүчингүй болгосон 25<br>Захиргааны хэм хэмжээний актад нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болсонд тооцсон | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn -д өөрчлөлт хийх | Улсын төсөв | | актын тоо 188 | болгосон байна. | | шийдвэрийг хянан баталгаажуулж, өөрчлөлт хөдөлгөөнийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсанд оруулан, Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсэн.<br>Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсанд байрших захиргааны хэм хэмжээний актад өөрчлөлт хөдөлгөөн оруулсан байдал:<br>Нэмэлт, өөрчлөлт -42<br>Хүчингүй болгосон -110 | |
| 3.23. | “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-ийг хуульд заасан хугацаанд хэвлэн нийтлэх | Улсын төсөв | Хэвлүүлсэн эмхэтгэлийн дугаарын тоо | 37 | 37 | /I-IV улирал/ | “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”-ийн 2024 оны 1-15 дахь дугаарыг эмхтгэн, эх бэлтгэлд шилжүүлж, хэвлэн нийтлүүлсэн.<br>Эмхтгэлийн танилцуулга, мэдээллийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудаст байршуулсан. 16, 17, 18 дахь дугаарыг 6 дугаар сарын 30-ны байдлаар эмхтгэн эх бэлтгэлд шилжүүлэн хэвлүүлсэн байна. | 100 |
| 3.24. | Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсанд хууль тогтоомж болон эрх зүйн бусад актыг бүрэн оруулсан эсэхэд ерөнхий хяналт тавих, мэдээлэл оруулагчид илэрсэн алдааны талаар буцаан мэдээлэх | Улсын төсөв | Хууль тогтоомж, эрх зүйн актад хяналт хийсэн тоо | 100 хууль, эрх зүйн акт хянасан | Мэдээллийн алдаа, зөрүүг тухай бүр хянаж, залруулах талаар мэдээлэл оруулагчид мэдээлж ажиллсан байна. | /I-IV улирал/ | 2024.01.01-2024.05.30-ны өдрийн байдлаар эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсанд нийт 591 хууль, эрх зүйн акт шинээр орсон байна. Үүнд:<br>- Монгол Улсын хууль-16;<br>- Монгол Улсын олон улсын гэрээ-3;<br>- Ерөнхийлөгчийн зарлиг-1;<br>- Улсын Их Хурлын тогтоол-46;<br>- Засгийн газрын тогтоол-161;<br>- Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр-5;<br>- Сайдын тушаал-95;<br>- Засгийн газрын агентлагийн даргын тушаал-12;<br>- Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж-8;<br>- Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр-139 тус тус орсон байна. www.legalinfo.mn цахим хуудсанд хяналтаар илэрсэн 52 эрх зүйн актын алдааг цаг тухайд нь холбогдох мэдээлэл оруулагчид мэдээлж, алдааг залруулж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.25. | Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn _цахим хуудаст мэдээлэл оруулагч байгууллагуудын мэдээлэл оруулагчдыг чадавхжуулах танхимийн сургалт зохион байгуулах | Улсын төсөв, Бусад эх үүсвэр | Сургалтын тоо; | Сургалтын тоо 1 | Сургалтын тоо 1, | /I-IV улирал/ | Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсанд системийн хөгжүүлэлтийг гүйцэтгэгч байгууллага "Интерактив" ХХК-аас мэдээлэл оруулагчдад зориулсан сургалтыг 2024.05.02-ны өдөр ХЗҮХ-ийн байранд зохион байгуулсан.<br>Сургалтад ХЗДХЯ-ны мэдээлэл оруулагч Д.Мөнхжаргал, УИХТГ-ын мэдээлэл оруулагч Ж.Мөнхдэлгэр, МУЕТГ-ын Хуулийн бодлогын газрын мэргэжилтэн Б.Лхамхүү, ҮХЦТГ-ын мэдээлэл оруулагч н.Даваажав, УДШ-ийн Номын сан, хууль тогтоомжийн лавлагаа хариуцсан мэргэжилтэн О.Батчимэг, ХЗҮХ-ийн ЭЗМНС-ийн мэдээлэл оруулагч Б.Оюунчимэг, ЭЗМНС-гийн хянагч Ч.Халиун, ЦМОНХТөвийн дарга Билигсайхан нарын 8 хүн хамрагдсан. | 100 |
| 3.26. | Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 онд хийж гүйцэтгэсэн судалгааны хэлэлцүүлэг зохион байгуулах | | Хэлэлцүүлгийн тоо | 0 | 4 удаа зохион байгуулсан байна. | Улирал бүр | 1. ХЗҮХ-ийн 2023 онд гүйцэтгэсэн "Прокурорын хараат бус байдал", "Прокурорын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" сэдэвт судалгааны тайлангийн хэлэлцүүлгийг 2024.02.06-ны өдөр зохион байгуулж ЭШАА О.Энхсүслэн, Х.Буянбат нар судалгааны тайлан, ЭША Б.Ариунжаргал шүүмж, дүгнэлт танилцуулж оролцсон.<br>2. 2024.05.24-ний өдөр зохион байгуулагдсан "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" судалгааны тайланг ЭШАА Х.Буянбат, ЭША Д.Дэмидханд нар хэлэлцүүлсэн. | 100 |
| **ЗОРИЛТ 4. Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангах, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, зүйлийг өргөжүүлэн, хүртээмжийг нэмэгдүүлэх /ХЗҮХ-гийн "2021-2024 үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"/** | | | | | | | | |
| 4.1 | Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудасны үйл ажиллагааны хэвийн найдвартай ажиллагааг хангаж, хяналтыг сайжруулж, цахим сангийн ашиглалтыг нэмэгдүүлэх | Улсын төсөв | Хандалтын тоо Хэрэглэгчийн тоо | Хэрэглэгчийн тоо: 20,903 Хандалтын тоо: 1,180,000 | Хандалт болон хэрэглэгчийн тоог 10 хувиар өсгөх | /I-IV улирал/ | Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудас тасалдалгүй, хэвийн ажиллаж, мэдээллийг тогтмол шинэчилж, олон нийт, хэрэглэгчдэд тогтмол хүргэж ажиллаж байна.<br>2024.01.01-2024.05.30-ны өдрийн байдлаар эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудаст<br>-Шууд хандалт: 4,334,449 буюу 267 хувиар<br>-Шууд бус хандалт: 26,971,936 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -Хэрэглэгчийн тоо: 23,676 буюу 13,3 хувиар өссөн.<br>Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсан дахь эрх зүйн актын ерөнхий хяналтыг ЭЗМНС-ийн хянагч тогтмол хийж гүйцэтгэж байна. | |
| 4.2 | Захиргааны хэм хэмжээний актын цаасан хувийг цахим хувьтай тулган хяналт хийн баталгаажуулж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсанд бүрэн эхээр нь байршуулах | Улсын төсөв | - Яамнаас хүлээн авсан захиргааны хэм хэмжээний актын тоо;<br>- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд оруулсан актын тоо;<br>- Архивласан актын тоо; | 597 эрх зүйн акт хүлээн авч, байршуулан архивласан. | ХЗДХЯ"аас ирсэн актыг хүлээн авч хуулийн хугацаанд байршуулж архивласан байна. | /I-IV улирал/ | 2024.01.01-2024.05.27-ны өдрийн байдлаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн 387 эрх зүйн актыг хүлээн авч, хяналт хийн, www.legalinfo.mn цахим хуудсанд хугацаанд нь оруулан ажиллаж байна. Нийт хүлээн авсан 387 эрх зүйн актаас:<br>- улсын бүртгэлд шинээр бүртгэгдсэн актын тоо: 387<br>- өөрчлөлт хөдөлгөөн оруулсан актын тоо: 46<br>Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд шинээр бүртгэгдсэн актын цаасан хувийг цахим хувьтай нь тулган баталгаажуулж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүрэн эхээр нь байршуулсан. Үүнд:<br>ЭЗМНС-д оруулсан эрх зүйн актын тоо: 311<br>засварласан эрх зүйн актын тоо: 573<br>backend.legalinfo.mn цахим хуудас дээр ерөнхий мэдээлэл засварласан: 224<br>ЭЗМНС-д оруулсан эрх зүйн актын хавсралт:<br>Засварласан актын хавсралт: 110<br>Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн. Архивласан эрх зүйн актын тоо 379 байна. | 100 |
| 4.3 | Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсанд хуулийн төсөл, захиргааны хэм хэмжээний актын төслийг байршуулах | Улсын төсөв | Цахим хуудаст байршуулсан хууль болон захиргааны хэм хэмжээний актын төслийн тоо | 53 төсөл | Хуулийн төсөл, захиргааны хэм хэмжээний актын төслийг тухай бүр байршуулсан байна. | /I-IV улирал/ | Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудасны санал авах хэсэгт 35 хуулийн төсөл, 2 захиргааны хэм хэмжээний актын төслийг байршуулж санал авах ажлыг зохион байгуулсан. | 100 |
| 4.4. | Монгол Улсын хууль тогтоомжийн англи хэл | Улсын төсөв | Цахим хуудсанд байршуулсан | 193 | Орчуулагдсан хууль | /I-IV улирал/ | Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсанд хуулийн албан бус орчуулга | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дээрх албан бус орчуулгыг эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсанд байршуулах | Бусад эх үүсвэр | орчуулгын тоо | | тогтоомжын орчуулгыг байршуулсан байна. | | байршуулах болоогүй. Учир нь хуулийн орчуулга хийх гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт хийгдэж, улмаар 2024.05.02-ны өдөр “Монгол өмгөөлөгч” хууль зүйн фирмтэй гэрээ байгуулан, эхний 65 хууль тогтоомжыг орчуулуулахаар хүргүүлсэн. | |
| 4.5 | Иргэд, олон нийтэд хууль тогтоомж, Хууль зүйн мэдээ, мэдээллийг энгийн ойлгомжтой хялбар байдлаар авах боломжийг бүрдүүлэн салбарын мэргэжилтнүүдтэй богино хэмжээний ярилцлага, мэдээлэл бэлтгэн хүргэх | Улсын төсөв | Ярилцлага, мэдээллийн тоо | 35 подкаст, ярилцлага, мэдээлэл | 35-оос доошгүй | /I-IV улирал/ | Хууль, эрх зүйн чиглэлээр дараах 21 сэдвээр подкаст, ярилцлага, мэдээлэл бэлтгэн түгээсэн. Үүнд:<br>1. “Боловсролын ерөнхий хууль” сэдвээр /хүрсэн хүний тоо 652/ https://fb.watch/sycik3aCy3/<br>2. “Дээд боловсролын тухай хууль” сэдвээр /хүрсэн хүний тоо 318/ https://fb.watch/sychkRHwKg/<br>3. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль” сэдвээр /хүрсэн хүний тоо 430/ https://fb.watch/sycgd1cYoT/<br>4. “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай” сэдвээр /хүрсэн хүний тоо 612/ https://fb.watch/syceRtVDVP/<br>5. “Хүний эрх гэж юу вэ” сэдвээр /хүрсэн хүний тоо 657/ https://fb.watch/sycamryM7M/<br>6. “Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлах тухай” сэдвээр /хүрсэн хүний тоо 483/ https://fb.watch/sycdCjFHR6/<br>7. “Жендерийн тэгш байдал ба мартын 8” сэдвээр /хүрсэн хүний тоо 529/ https://fb.watch/syen-_1lnx/<br>8. “Ажлын байран дээр эмэгтэй хүн болж төрснөөрөө ялгаварлан гадуурхалтад өртдөг” /хүрсэн хүний тоо 1,500/ https://fb.watch/syc8REV8OI/<br>9. “Эрэгтэйчүүдийн оролцоогүйгээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах боломжгүй” сэдвээр /хүрсэн хүний тоо 2,400/ https://fb.watch/syc7ISLljk/<br>10 “Эрчүүдэд тулгамдаж буй асуудал” /хүрсэн хүний тоо 1002/ https://fb.watch/syc6bToMKI/<br>11. “Оюуны өмч ба эдийн засгийн хөгжил” сэдвээр /хүрсэн хүний тоо 709/ https://fb.watch/sycNEAEQrJ/<br>12. “Үе тэнгийн дарамт дээрэлхэлт” сэдвээр /хүрсэн хүний тоо 1100 / https //fb.watch/sycTm5sdZ8/<br>13. “Сонгох, сонгогдох эрх” сэдвээр /хүрсэн хүний тоо 483/ https://fb watch/sycWVdWDR2/ | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 14. “Суррон, скүүтэртэй замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарах зүйлс” сэдвээр /хүрсэн хүний тоо 2800 / https://fb.watch/sycZR66HW0/<br>15. “Зуны улиралд орон байрны хулгайн гэмт хэрэг их гардаг” сэдвээр /хүрсэн хүний тоо 621 / https://fb.watch/syd0EAjE2t /<br>16. “Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр /хүрсэн хүний тоо 197 / https://fb.watch/syd3AIqVJg/<br>17. “Замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарах нь” сэдвээр контентыг https://fb.watch/synADCh-Vs/ тус тус бэлтгэн түгээсэн.<br>2024.06.30-ны өдрийн байдлаар<br>- “Сонгох, сонгогдох эрх” сэдвээр<br>- “Хулгайлах гэмт хэрэг” сэдвээр<br>- “Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль” сэдвээр<br>- “Ажил амралтын цаг ба ээлжийн амралттай холбоотой харилцаа” сэдвээр дээрх 4 контентийг түгээхээр ажиллаж байна. | |
| 4.6 | Иргэд, олон нийтийн хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор хууль зүйн яамны харьяа төрийн байгууллагуудтай хамтарсан аянг санаачлан зохион байгуулах | Улсын төсөв, | Аян зохион байгуулсан тоо | - | 2-оос доошгүй аян | /I-IV улирал/ | “Мансуурлын эсрэг хамтдаа” аяны хүрээнд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ судалгааны тайлантай танилцаж, мэдээлэл бэлтгэн нийтлүүлсэн. ХЗҮХ-ийн 2024.06.06 өдрийн 01/242 тоот албан бичгээр ХЗДХСайдын эрхлэх асуудлын хүрээнд ЦЕГ, ШШГЕГ, ХЗТТ, ХХЕГ, ГИХГ, ШШЕГ, ДХИС, ТТАХНЭ, СЭМҮТ, ХГБХХЕГ зэрэг байгууллагуудыг аянд нэгдэхийг уриалсан. | 100 |
| 4.7 | Иргэдээс хууль зүйн зөвлөгөө мэдээллийн утсанд /1800-1202/ ирж байгаа дуудлага мэдээлэлд үндэслэн тухайн цаг үед хэрэгцээтэй байгаа хууль тогтоомжийг сурталчлах зурагт хуудас, бичлэг, зэрэг хэлбэрээр хийж, | Улсын төсөв, | Зурагт хуудас, бичлэг зэрэг контентийн тоо | 40 | 40-өөс доошгүй зурагт хуудас контент зэрэг хийж түгээсэн байна | /I-IV улирал/ | Нийт 16 төрлийн 77 зурагт хуудас болон 19 “reels” бэлтгэн олон нийтэд түгээсэн байна. | 100 |